



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/804

Арвайхээр

Буцалтгүй тусламж олгох тухай

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын 2018 оны а/676 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам”-ын 2.1, 2.2, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргад хандаж мөнгөн тусламж хүсч өргөдөл ирүүлсэн өндөр настай, өрхийн орлогогүй, хүнд өвчтэй, амьжиргааны баталгаажих түвшин доогуур орлоготой хавсралтад дурьдагдсан нэр бүхий 10 иргэнд 1600000 (нэг сая зургаан зуу мянга) төгрөгний нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгосугай.

2. Дээрх 1600000 (нэг сая зургаан зуу мянга) төгрөгийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101525

Аймгийн Засаг даргын 2019 оны 19  
дугаар сарын 27-ны өдрийн 4804 дугаар  
захирамжийн хавсралт

НЭГ УДААГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ  
ИРГЭДИЙН НЭРС

№	Овог, нэр	Оршин суугаа хаяг	Мөнгөн дүн
1.	Н.Сорхүрэн	Арвайхээр сумын 11 дүгээр баг, 11-65-5	200000
2.	П.Тогоохүү	Арвайхээр сумын 2 дугаар хороо	200000
3.	Б.Дашдондов	Уянга сумын 5 дугаар баг	200000
4.	П.Ганхуяг	Арвайхээр сумын 3 дугаар баг, 3-8-12	200000
5.	Б.Гэлэгчимэд	Арвайхээр сумын 10 дугаа баг	200000
6.	Л.Алтанцэцэг	Арвайхээр сумын 4 дүгээр баг, 4-40-3	200000
7.	Л.Нансалмаа	Арвайхээр сумын 13 дугаар баг, 36-2-16	200000
8.	Д.Болд	Арвайхээр сумын 11 дүгээр баг, 11-39-11	100000
9.	Л.Наранцэцэг	Арвайхээр сумын 9 дүгээр баг, 9-96-6	50000
10.	А.Цэндбаяр	Арвайхээр сумын 8 дугаар баг, 8-33-236	50000
<b>Нийт дүн</b>			<b>1600000</b>